



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/НВ

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Бугат сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Энх алтаргана” ХХК-тай 218,220,079 (хоёр зуун арван найман сая хоёр зуун хорин мянга далан ес) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Энх алтаргана” ХХК-ийн захирал (А.Энхжаргал)-д даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журам гэрээний дагуу аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010098

Аймгийн Засаг даргын 2023 оны  
03 дүгээр сарын 15-ний өдрийн А/НБ  
тоот захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	3,823,937	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	3,314,841	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	-	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	-	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувь байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	50 хоног	Ү.Бямбасүрэн